



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар №226

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Боловсролын салбарын “Ховдын Ирээдүй” төсөл арга хэмжээг боловсруулахад зөвлөн туслах, судалгаа хийх, өнөөгийн түвшинг тогтоож, сайжруулахад шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, судлаачдын багийн сургалт зохион байгуулах зардалд 7,970,000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Зардалд зарцуулах 7,970,000 (Долоон сая есөн зуун далан мянган) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 5.4 дэх заалт Боловсролын салбарын төсөл арга хэмжээнээс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батсайхан), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 0700

Zah A/226 Och

Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дүгээр сарын 08-ны өдрийн
А/226 дугаар захирамжийн хавсралт



**“ХОВДЫН ИРЭЭДҮЙ” ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ БОЛОВСРУУЛАХАД ЗӨВЛӨН
ТУСЛАХ, СУДАЛГАА ХИЙХ, ӨНӨӨГИЙН ТҮВШИНГ ТОГТООЖ, САЙЖРУУЛАХАД
ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, СУДЛААЧДЫН БАГИЙН СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Ментор багийн гишүүдийн ажлын хөлс	Хүний тоо	3	2,000,000	6,000,000
2	Судлаачдад хийх сургалтын зардал (ШУА-ын эрдэм шинжилгээний ажилтан П.Цэенханд, Г.Саруул)	Хүний тоо	2	400,000	800,000
3	Сум байгууллагад хэлэлцүүлэг, судалгаа хийх багийн шатахууны зардал (Алтай, Зэрэг, Мөст, Манхан, Чандмань, Мянгад, 100км-т 20 литр бинзэн)	Литр	418	2,800	1,170,000
	Дүн				7,970,000

-оОо-